

Ундай Голын Гольдролыг Өөрчлөхтэй Холбоотой Гомдол
Хөндлөнгийн Шинжээчдийн Баг
Ажлын Удирдамж

Танилцуулга

2013 оны 2 дугаар сард Монгол Улсын Өмнийн Говь дахь Оюу Толгой уурхайн (цаашид “Төсөл” гэх) ойролцоо оршин суудаг нутгийн малчид болон ард иргэд орон нутгийн “Говийн газар шороо” ТББ, мөн үндэсний хэмжээний “ОТ Хяналт” ТББ-ын дэмжлэгтэйгээр Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газарт (цаашид “CAO” гэх)¹ хандан Ундай голын гольдролыг өөрчлөх, Бор овоогийн задгайг шилжүүлэхээр Төсөл төлөвлөсөнтэй холбогдуулан гомдол гаргасан болно. CAO-ын Омбудсмэн/Маргааныг шийдвэрлэх үйл ажиллагааны хүрээнд эдгээр асуудлууд болон Ундай голын чухал цутгалан болох Халив-Дугатын голын² гольдролыг өөрчлөхтэй холбоотой асуудлуудыг судлуулж CAO болон кейсийн талууд болох Малчдын Төлөөлөгчид (цаашид “MT” гэх) болон Оюу Толгой ХХК (цаашид “ОТ” гэх)-д дүгнэлт зөвлөмжөө гарган танилцуулах Хөндлөнгийн Шинжээчдийн Баг (цаашид “Шинжээчдийн Баг” гэх) ажилуулахаар боллоо.

Зорилго

Шинжээчдийн Багийн зорилго нь Ундай гол, Бор Овоогийн Задгай, Халив-Дугатын гол гэсэн гурван чухал усны эх үүсвэрт Төслөөс учруулж буй нөлөөллүүдэд үнэлгээ хийж, тэдгээр нөлөөллүүд малчдын бэлчээр, усны хүртээмж, усны чанарт ямар хохиролтой болохыг тогтооход оршино. Нэн ялангуяа Оюу Толгой компаниас Ундай голын гольдролыг өөрчлөх, Бор овоогийн задгайг шилжүүлэх, хаягдал агуулах байгууламж, чулуун хаягдлын овоолгын нөлөөллүүдийн талаар өгсөн баримт мэдээлэл үнэн зөв эсэх, өөр хувилбар, өөрчлөлт байж болох эсэх, түүнчлэн малчдын бэлчээр, усны хүртээмж, усны чанарт учрах нөлөөллүүдээс зайлсхийх буюу багасгах ямар нэмэлт арга хэмжээ авч болох тухайд үнэлгээ өгөхийг малчид Шинжээчдийн Багаас хүсч байгаа болно.

Энэхүү ажлыг хийж гүйцэтгэхэд баримтлахаар хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг дурдвал:

- Шинжээчдийн багийн бүрэлдэхүүн болон тэдний баримтлах аргачлалын талаар оролцогч талууд нэгдсэн итгэл үнэмшилтэй байх хэрэгцээ шаардлага;
- Талуудын нэн тэргүүний чухал асуудлыг харилцан ойлгосон байдалд тулгуурлан тус ажлыг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх; ба
- Цаг хугацаа, өртөг зардлын хувьд юу нь бодит амьдралд нийцсэн практик, хэрэгжүүлж болохуйц вэ гэсэн асуудал болон харилцан буюу дундын хариуцлагатай байх цар хүрээ гэсэн асуудлын хоорондох тэнцвэрийг хадгалах.

Гишүүнчлэл ба сонгох шалгуур

Шинжээчдийн Баг нь 3-5 тооны шинжээчдээс бүрдсэн баг байх ба дотоод болон/ эсвэл гадаадад туршлага хуримтлуулсан хоёроос доошгүй усны шинжээч, гидрогеологич, томоохон хэмжээний уурхайн байгаль орчин, ард иргэдэд учруулах нөлөөллийг үнэлэх шинжээч, бэлчээр, говийн бэлчээрийн газрын ашиглалтын шинжээчдээс бүрдсэн байна. Шинжээчдийг тэдний хөндлөнгийн хараат бус байдал, мэдлэг чадвар, найдвартай хариуцлагатай байдал,

¹ CAO нь Дэлхийн Банкны Группын Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) болон Олон Талт Хөрөнгө Оруулалтын Даатгалын Байгууллагат (ОТХОДБ) хөндлөнгийн хараат бус дэмжлэг туслалцаа үзүүлэх механизм юм. Нэмэлт мэдээллийг <http://www.cao-ombudsman.org/-ээс> үзнэ үү.

² Зарим малчид энэ голыг Халив гол, нөгөө хэсэг нь Дугат гол ч гэдэг. Ойлгомжтой байлгах үүднээс энд туждаа “Халив-Дугатын гол” хэмээн нэрлэлээ.

талуудтай үр бүтээлтэй хамтран ажиллах чадавх, Төслийн талаарх мэдлэгийг харгалзан үзэж САО сонгоно (цаашид талууд харилцан хүлээн зөвшөөрөх шаардлагатай байгаа)

[Тэмдэглэл: Иймд ОТ / Рио Тинтод ажиллаж байгаагүй талуудын аль аль нь хүлээн зөвшөөрсөн шинжээчдийг олон асуудал хүндрэлтэй байж болох юм. Шинжээчдийн хийж ажлын хамрах хүрээнд хийгдэх ажлыг тэнцвэртэй, аль нэг талыг баримтлалгүйгээр судалгааг хийх хүсэл, эрмэлзлэлтэй болохыг нарийн шалгуураар хувь хүн бүрээр нягталж үзсэний дараа ОТ / Рио Тинтод ажиллаж байсан туршлагатай шинжээчдийг нэмж оруулж болно.]

Эцсийн сонгон шалгаруулалтанд санал болгох шинжээчдийн баг дараах ажил мэргэжлийн ур чадварын шаардлагыг багаараа хангасан байвал зохино:

Академийн буюу боловсролын шалгуур

- Хийлгэхээр төлөвлөж буй ажлын шаардлагад нийцсэн боловсролын зэрэг ба/эсвэл суурь мэргэшилтэй байх:
 - Уур амьсгал, газрын гадаргын ба гүний усны судлал гэх мэтчилэн усны эргэлтийн үндэс;
 - Усны хими;
 - Хүний үйл ажиллагаа усны чанар, хэмжээнд ямар хор хөнөөл учруулдаг болох;
 - Төсөл усыг хэрхэн ашиглаж буй, тэр нь усны чанар хэмжээнд ямар өөрчлөлт үзүүлэх;
 - Усны чанар, стандартууд, тэдгээрийг янз бүрээр ашиглах;
 - Мониторингийн үндсэн арга хэлбэрүүд;
 - Мэдээ мэдээллийг тайлж унших, зурган дүрслэл, статистик.
 - Цөлийн экологийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай
 - Нүүдэлчдийн байгалийн баялагийн ашиглалтын талаар мэдлэгтэй,
 - Гидрологийн төвөгтэй судалгааны ажиглалт дүгнэлтийг нүүдэлчин иргэдийн усны хүртээмжид нөлөөлөх нөлөөллийн талаас нь тодорхой тайлбарлан ойлгуулж чадах чадвартай

Холбогдох ажлын туриллага

- Бодит судалгааны ажил, академийн судалгааны ажил хийж байсан, олон улсын стандартад нийцсэн мэргэжил нэгт хүмүүсийн хяналт дүгнэлт бүхий шинжлэх ухааны бодит үндэслэлд тулгуурласан нөлөөллийн үнэлгээ хийж байсан, материал, баримт бичгийн судалгаа хийж байсан гэх мэт.
- Төр, засгийн газар, салбар, олон улсын байгууллага болон нөлөөлөлд өртсөн иргэдтэй хэцүү төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд ажиллаж байсан туршлагатай ОТ-н төслийн аливаа зураг төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажил хийж байгаагүй

Бодитой буюу объектив байх, хариуцлага хүлээх чадвар

- Нэр дэвшигчийн өмнө нь хийж гүйцэтгэж байсан ажил нь аливаа байр суурийг дэмжсэн эсвэл эсэргүүцсэн үйл явцад “нөлөөлж, өмгөөлж хамгаалаагүй ” байх, мэргэжлийн үнэлгээнд тулгуурлан төвийг сахисан, бодитой буюу объектив нотолгоо баримт/зөвлөмж дүгнэлт/санал гаргаж чаддаг байх
- Нэр дэвшигч нь өмнө нь ОТ эсвэл Рио Тинтод ажил үйлчилгээ үзүүлж байгаагүй, эсвэл эдгээрийн аль алинд албан тушаал хашиж байгаагүй байх

Дор дурьдсан Ажлуудыг хийж гүйцэтгэхэд нэмэлт шинжээч шаардлагатай гэж үзвэл сонгогдсон шинжээчид тохирох хүнийг нэр дэвшүүлж саналаа САО-д тавина.

Аргачлал

Шинжээчдийн баг сонгогдмогцоо нүүдлийн зан заншил амжиргаатай хүмүүсийн онцлогыг харгалзан, уул уурхайн төслүүд нүүдэлчин хүмүүс болон нүүдэлчин хүмүүсийн байгалийн баялагийн хэрэгцээнд үзүүлэх нөлөөллийг үнэлэх олон улсын тэргүүн туршлагад тулгуурлан судалгааны бүрэлдэхүүн хэсэг тус бүрт ашиглах аргачлалын төслийг боловсруулна. Аргачлалыг судалгааны ажлаа эхлүүлэхээс өмнө батлуулахаар МТ болон ОТ-д танилцуулна.

Санал болгож буй аргачлал нь наад зах нь дараах зүйлсийг багтаасан байна:

- Нөлөөлөлд өртсөн малчид, орон нутгийн ба төвийн засаг захиргаа, яамд, агентлагуудын албан тушаалтнуудтай хийх уулзалт ярилцлага;
- Холбогдох бүх инженеринг, ус, хөрс, ургамлын мониторинг ба сорил туршилтууд, удирдлагын болон нөлөөллийг бууруулах төлөвлөгөө, тайлангийн судалгаа,
- Компанийн нийгмийн ба байгаль орчны асуудал хариуцсан ажиллагсад болон зөвлөхүүдтэй уулзах, уурхайн талбайд очиж газар дээр нь танилцах.

Ажлын хамрах хүрээ

Дээр дурдсан зорилгодоо хүрэхийн тулд Шинжээчдийн Багийн гишүүд талуудын хувьд дор дурдсан нэгдмэл чухал асуудлаар судалгаа хийж зөвлөмж дүгнэлт гаргана: (1) Ундай голын голидрол өөрчлөх; (2) Бор Овоогийн задгайг нүүлгэн шилжүүлэх; ба (3) Халив-Дугатын голын голидрол өөрчлөх.

Ажлын өртөг зардал, техник эдийн засгийн үндэслэл, тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах хугацаа зэргийг харгалзан Шинжээчдийн Багийн санал зөвлөмжийн дагуу эдгээр ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ. Улмаар 1 дэх үе шатанд хийгдсэн ажлын үр дүнд үндэслэн ажлын хамрах хүрээг тэлж нэмэгдүүлэх боломжтой.

Эхний Үе Шатад Шинжээчдийн Баг нь дараах асуудалтай холбогдуулан судалгаа явуулж зөвлөмж дүгнэлт гаргана –

1 ДЭХЬ ҮЕ ШАТ

- Ундай голын голидрол өөрчлөх барилгын ажил, загвар дизайн, ялангуяа:
 - Ундай голын өмнө нь малчдыг хангаж байсан усны адил чанар, хэмжээ бүхий усаар малчдыг хангаж чадахуйцаар Ундай голын голидролыг өөрчлөх төслийн загвар гарч баригдсан эсэх;
 - Ундай голын голидрол өөрчилсн улмаас малчдын бэлчээр, усны хүртээмж, усны чанарт учрах шууд, дам болон хуримтлагдах хам нөлөөлөл; ба
 - Ундай голын голидролыг өөрчлөх болон түүний холбогдох мониторинг ба/буюу нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний малчдын бэлчээр, усны хүртээмж, усны чанарт учруулах нөлөөллөөс зайлсхийх эсвэл нөлөөллийг бууруулж болохуйц өөр боломжит хувилбар байгаа эсэх, өөрчилж болох эсэх.
- Бор-Овоогийн задгайг шилжүүлэхээр төлөвлөж буй төлөвлөлт, ялангуяа:
 - Бор Овоогийн задгайг шилжүүлэн байрлуулахаар санал болгосон загвар дизайн нь хир тохиромжтой болох, хуучин задгайн экологи, соёл ёс заншил, нийгмийн үүргийг урьдын адил орлохуйц аливаа өөр хувилбар загвар байж болох эсэх; ба
 - Бор Овоогийн задгайг шилжүүлэн байршуулсны улмаас малчдын бэлчээр, усны хүртээмж, усны чанарт учрах шууд, дам болон хуримтлагдах хам нөлөөлөл.

- Задгайн загвал дизайныг малчид, шинжээчид хамтран гаргахад идэвхтэй оролцох боломж бололцоо – талуудын хувьд энэ асуудлаар урагш ахих гэдэг бол хамгийн чухал асуудал.

Дээрх ажиглалт дүгнэлтэнд үндэслэн, Шинжээчдийн Баг нь дор дурдсан асуудлыг хамарсан, гэхдээ тэдгээрээр хязгаарлагдахгүй илүү дэлгэрэнгүй судалгааг дараагийн үе шатанд хийх техник эдийн засгийн үндэслэлийн талаар зөвлөмж гаргана:

2 ДАХЬ ҮЕ ШАТ

- Халив-Дугатын голд үзүүлэх нөлөө ба Ундай голын сав газарт үзүүлэх хуримтлагдсан хам нөлөөлөл, ялангуяа:
 - Халив-Дугатын голын гольдролыг өөрчилсөн эсэх, эсвэл Ундай болон Халив-Дугатын голуудын гольдролыг өөрчилснөөр бүс нутгийн ус, бэлчээрийн нөөцөд учруулж болох хам нөлөөлөл;
 - Хаягдал хадгалах байгууламж ус алдаж байгаа эсэх, ирээдүйд ийнхүү ус алдах эрсдэл байгаа эсэх, ийнхүү ус алдсанаар Халив-Дугатын гол болон малчид, мөн малын аливаа бусад ундны усны эх үүсвэрт үзүүлэх болзошгүй нөлөөлөл; ба
 - Халив-дугатын голын нөлөөллийг бууруулах зорилгоор Төслийн хаягдал хадгалах байгууламж эсвэл холбогдох мониторинг болон/эсвэл нөлөөллийг бууруулах төлөвлөгөөг өөрчлөх боломж.

Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн I ба II үе шатанд хийсэн ажлын үр дүн, зөвлөмжийг мэргэжил нэгт шинжээчид хянахад нээлттэй байлгана.